

**ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН НИСЭХ БА ОРОН НУТГИЙН
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖИЙН
СИМУЛЯЦИЙН СУДАЛГАА**

*Б. Болормаа
Доктор, ахлах багш*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

bolorma.b@must.edu.com

*Г. Эрдэнэтуяа
Төрийн захиргааны менежментийн магистрант*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн ахисан түвшний сургууль*

g_tuyah@yahoo.com

Хураангуй: Орон нутгийн эдийн засгийг тэлэх улмаар улсын төсвийн ачааллыг бууруулах асуудал нь манай улсын эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг батжуулахад нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой гол асуудлын нэг юм. Энэ асуудлыг шийдэхэд жинтэй хувь нэмэр оруулах боломжтой салбаруудын нэг бол аялал жуулчлалын салбар юм. Аялал жуулчлалын хөгжилд нөлөөлдөг голлох хүчин зүйлсийн нэг бол тээвэр бөгөөд тэр дундаа агаарын тээврийг хөгжүүлэх хэрэгцээ их байна. Энэ хэрэгцээтэй уялдан Ерөнхий зориулалтын нисэхийн салбар(ЕЗН)-ыг хөгжүүлэх шаардлага гарч ирээд байна. Мөн улсын төсвөөс санхүүждэг агаарын тээвэртэй байсан, зах зээлийн баримжаатайгаар ЕЗН-ийг хөгжүүлж ирсэн түүхгүй манайх шиг хуучин коммунист жижиг улс орнуудад орон нутгийн эдийн засаг, аялал жуулчлалын хөгжлийг дэмжихэд ЕЗН-ийг хөгжүүлэх үндэслэлийг тогтоох, эдийн засгийн үр өгөөжийг судалсан судалгааны ажил төдийлөн их хийгдээгүй байдаг. Онол, практикийн энэ хоёр хэрэгцээг хангах зорилго тавьж энэхүү судалгааны ажлыг хийсэн. Байгалийн түүхийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой Өмнөговь аймгийн жишээн дээр ЕНЗ-ийг орон нутагт хөгжүүлэх боломжийг судалсан. Судалгааны зорилгоо биелүүлэхдээ нийтийн бодлогын судалгааны эдийн засгийн үр өгөөжийн симуляцийн судалгааны аргыг хэргэлэсэн. Судалгааны ажлын явцад зах зээлийн эдийн засгийн баримжтайгаар агаарын тээврийг хөгжүүлж ирсэн уламжлалгүй, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой өргөн уудам нутагтай манай орон шиг жижиг улс орнуудад ЕЗН-ийн салбар орон нутгийн эдийн засгийг тэлэхэд жинтэй хувь нэмэр оруулах бүрэн боломжтой судалгааны үр дүн гарсан.

Түлхүүр үгс: Ерөнхий зориулалтын Нисэх (ЕЗН), аялал жуулчлал, орон нутаг, нисдэг тэрэг, зардал-үр ашиг

УДИРТГАЛ

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно” гэсэн зорилт дэвшүүлсэн байдаг (УИХ, 2020). Мөн уг бодлогын баримтын бичгийн 4.2 дугаар зорилт дээр дор бичсэн хоёр гол зорилгыг дэвшүүлсэн байдаг (УИХ, 2020).

- “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн байна”, .
- “Иргэний нисэхийн дэд бүтэц, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлсэн байна.”

Дээр дурдсан зорилгуудаас гадна тус бодлогод бүс, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлохдоо “эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ” гэсэн байдаг (УИХ, 2020).

Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн дээр дурдсан зорилгуудыг нэгтгэн товч хураангуйлан авч үзвэл бүс нутгийн зах зээлийг чиглэсэн байгаль орчинд ээлтэй, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэй аялал жуулчлал, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлнэ гэсэн үнэ цэнэтэй зорилгуудыг дэвшүүлсэн байна. Энэ бодлогын зорилгын товч дүр зураглалаас харах юм бол байгаль орчинд ээлтэй ногоон аж үйлдвэр, эдийн засгийн үр өгөөж гэсэн хоёр шаардлага аялал жуулчлал, ерөнхий зориулалтын нисэхийн салбарыг хөгжүүлэхэд баримтлах гол шалгуур болжээ.

Байгаль орчинд ээлтэй ногоон аж үйлдвэрийн гэдэг шалгуур үзүүлэлтийн дагуу аялал жуулчлалын салбарыг харвал газар нутгийн 76.8% нь хөрсний доройтойлд орсон бөгөөд 22.9% нь хөрсний доройтол нь ноцтой хэмжээнд хүрсэн манай орны хувьд газрын тээвэр зонхилсон өнөөгийн аялал жуулчлалын аж үйлдвэрийн практик, логистикийг өөрчлөх хэрэгцээ шаардлага гарч ирсэн байна (Han, J., Dai, H. & Gu, Z., 2021). Ерөнхий зориулалтын нисэхийн салбар энэ асуудлыг шийдэх үнэ цэнэтэй шийдлүүдийн нэг байх бүрэн боломжтой. Гэхдээ байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх төрийн бодлогын зорилгыг биелүүлэхэд ерөнхий зориулалтын нисэхийн давхар хөгжүүлэх талаар эдийн засаг, нийтийн бодлогын шинжилгээний судалгааны ажил ховор байна. Ерөнхий зориулалтын нисэх Монгол орны орон нутгийн эдийн засгийг тэлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нийтийн бодлогын эдийн засгийн шалгуураар хэр их үр өгөөжтэй байх вэ гэсэн өмнө төдийлөн их судлагдаж байгаагүй судалгааны асуудлыг дэвшүүлэн судалгаа хийсэнд бидний судалгааны ажлын ач холбогдол, үнэ цэнэ оршино.

Аялал жуулчлал бол дэлхийн эдийн засагт чухал байр суурь эзлэх томоохон салбар бөгөөд сүүлийн тавин жилд энэ салбарын үзүүлэлт гуч дахин өсч 21-р зууны эхээр 670 саяд байсан уулчдын тоо 2018 оны байдлаар 1.4 тэрбумд хүрч эдийн засгийн эргэлт нь 1626 триллион доллараар хэмжигдэж байна.

НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын урт хугацааны урьдчилсан таамаглалаар аялал жуулчлалын жилийн дундаж өсөлт 4.5%-тай байгаа (UNTWO, 2018) ба үүнд дэлхийн улс орнуудын эдийн засгийн өсөлт, агаарын тээврийн нислэгийн хөгжил, технологийн өөрчлөлт, шинэлэг бизнесийн загварчлал, олон улсын визний хөнгөлөлт, хил гаалийн хялбарчилсан зохицуулалт зэрэг олон дэвшилтэт үйл явдлууд нөлөөлсөн гэж үзэж байна (Н.Сүмбэр, 2019). Энэ өсөлтийн үзүүлэлт Монгол оронд ч мөн үр нөлөөгөө үзүүлж манай орон 2019 оны байдлаар 577262 жуулчин хүлээн авсан нь өмнөх оны мөн үеэс 9 хувиар нэмэгдэж аялал жуулчлалаас олох орлого 10.2 хувиар өссөн дүнтэй гарсан байна (Байгаль орчин аялал жуулчлалын яам, 2019). Гэхдээ Монгол Улсад ирсэн жуулчид нь дэлхийн аялал жуулчлалын зах зээлийн дөнгөж 0,034% - ийг эзэлдэг- маш бага үзүүлэлт юм. Ерөнхий зориулалтын нисэхийн хөгжил нь энэ үзүүлэлтийг жинтэй нэмэгдүүлэх бүрэн боломжтой салбар юм. Тиймээс энэ талын судалгаа хэрэгцээ манай орны аялал жуулчлын салбарт их байна.

Эдүгээ Монголд ирсэн жуулчдын олонхи нь өмнийн говийг заавал зорин ирж аялдаг гэсэн тооцоолол бий. Зарим нь палентологийн ертөнцөөр аялж, зэрлэг амьтад үзэх, нүүдлийн соёлтой танилцах гэж ирдэг бол нөгөө хэсэг нь байгалийн сайханд аялах, тэмээ унах гэх мэт олон хүсэл сонирхолдоо хөтлөгдөн ирдэг. Учир нь Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт дэлхийд хосгүй, дахин давтагдашгүй байгалийн бүс бүслүүр, биологийн төрөл зүйлс, эртний амьтан, ургамлын чулуужсан яс, Монголын нүүдэлчин амьдрал, тэмээний соёл, хүний гарт харьцангуй бага өртөж, унаган төрхөөрөө үлдсэн уулс, цөл, тал, хөндийнүүд бий.

Хүснэгт 1. Өмнөговь аймгийн жуулчдын статистик



Дээрх хүснэгтийн статистикийн үр дүнгээс харвал Өмнөговь аймагт ирэх жуулчдын тоо жил ирэх тусам тогтвортой нэмэгдэж ирсэн байна. Энэ хандлага нь тус аймгийн эдийн засгийг тэлэх, олон талт болгоход аялал жуулчлалын салбар жинтэй хувь нэмэр оруулах боломжтой болохыг харуулж байна. Гэхдээ газрын тээврээр аялах жуулчдын тоо нэмэгдвэл говийн эмзэг экосистемд сөргөөр нөлөөлөх эрсдэл байна. Ерөнхий зориулалтын нисэхийн салбарын хөгжил нь энэ эрсдлийг бууруулах логистикийн хувилбаруудын нэг юм. Тиймээс бид Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх эдийн засгийн үр өгөөжийн симуляцийн судалгааны ажлыг хийхээр Өмнөговь аймгийн аялал жуулчлалын салбарыг сонгож авсан.

Судалгааны ажлын хүрээнд судалгааны асуултын хариултыг шинжлэх ухааны системтэй судалгааны аргаар олж тогтоохын тулд дор бичсэн судалгааны зорилгуудыг дэвшүүлэн ажилласан.

1. Эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулх шинэ аж үйлдвэрийг хөгжүүлэх талаар хийгдсэн гадаад, дотоодын судалгааны ажлуудтай танилцан, үнэлгээ хийн бидний судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдлыг тодорхойлох.
2. Судалгааны асуулт болон өмнөх судлагдсан байдалд хийсэн үнэлгээнд тулгуурлан судалгааны таамаглалыг дэвшүүлэх.
3. Судалгааны таамаглал, гарах үр дүнг төв болгон судалгааны таамаглалыг шалгах тоон судалгааны ажлын төлөвлөгөө гаргах.
4. Тоон судалгааны аргаар өгөгдөл цуглуулан эдийн засгийн үр өгөөжийн шинжилгээний аргаар өгөгдөлд шинжилгээ хийж, үр дүнг тайлж унших
5. Нийтийн бодлогын эдийн засгийн үр өгөөжийн шинжилгээнд тулгуурлан судалгааны таамаглалын дагуу онол, практик, бодлогын хүрээнд судалгааны ажлын дүгнэлт хийх

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Аялал жуулчлал, орон нутгийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөний тухай бидний үзэл бодлыг цэгцлэхийн тулд аялал жуулчлалын аж үйлдвэр эдийн засагт хэрхэн нөлөөлдөг тухай онолын дүр зураглалыг гаргах нь зүйтэй юм. Аялал жуулчлалын зарцуулалт нь ҮНБ болон хөдөлмөр эрхлэлт гэх мэт макро эдийн засгийн үзүүлэлтүүд нөлөөлөл үзүүлдэг. Олон орны эрдэмтэд энэ талаас нь аялал жуулчлал ба эдийн засгийн харилцан хамаарлыг судалсан байдаг. Ихэнх судалгааны ажил регресс, хугацааны цуваа цагийн шинжилгээ гэх мэт статистикийн судалгааны аргуудыг хэрэглэн энэ харилцан хамаарлыг судалсан байдаг. Жишээ нь Файса тэргүүтэй эрдэмтэд Африкийн

эдийн засгийн өсөлт, хөгжилд үзүүлэх аялал жуулчлалын үр нөлөөг судалсан байдаг (Fayissa, B., Nsiah, C. & Tadasse, B., 2008).

Зарим судлаачид аялал жуулчлалын салбар үндэсний эдийн засгийн хөгжилд ямар нөлөөлөл үзүүлдэгийг судлахдаа харьцуулсан судалгааны аргыг сонгон олон орны жишээн дээр ажиглалт хийн судалжээ. Тухайлбал Фигини ба Виси нар 150 гаруй орны 1980-2005 оны хоорондох эдийн засагт аялал жуулчлалын салбарын үзүүлсэн үр нөлөөг харьцуулан судалсан. Тэдний судалгааны ажлын үр дүн аялал жуулчлалд суурилагагүй улс орнуудтай харьцуулахад, аялал жуулчлалд суурилсан улс орнуудын эдийн засгийн хөгжлийн хурд нь бага болохыг тогтоосон байна (Figini, P. & Vici, L., 2010). Гэхдээ уг судалгааны ажлын өгөгдлийн найдвартай байдал эргэлзээтэй гэж зарим судлаачид үздэг.

Харин Брау тэргүүтэй судлаачдын 1980-2003 оныг хамарсан судалгааны ажлын үр дүнгээс харвал аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлсэн жижиг улс орнуудын эдийн засаг статистикийн ач холбогдолтойгоор өсөн нэмэгдсэн судалгааны үр дүн гарсан. (Brau, R., Lanza, A. & Pigliaru, F., 2007). Эдийн засгийн үр өгөөж, нэн ялангуяа зардал үр өгөөжийн шинжилгээ хийх нь төрийн бодлого, түүний хөрөнгө оруулалтын үр ашиг талаас аялал жуулчлалын салбарын эдийн засгийн цэвэр үр өгөөжийг тогтооход үр ашигтай болохыг тогтоожээ. (Burgan, B. & Mules, T., 2001) (Dwyer L., Forsyth, P. & Spurr, R., 2006) (Dwyer, L., Forsyth, P. & Dwyer, W., 2010). Зочид буудал (Forbes, 1976), далайн эргийг хамгаалах (Raybould, M. & Mules, T., 1999), масс аялал жуулчлал (Vanhove, 2003) гэх мэт тодорхой аялал жуулчлалын төслүүд дээр зардал үр өгөөжийн шинжилгээний судалгааны ажлууд их хийгддэг.

Өмнөх судалгааны ажлуудын ерөнхий хандлага, чиглэлүүдийг тоймлон харахад аялал жуулчлалын салбарт түшиглэн орон нутгийн эдийн засгийг тэлэхэд ерөнхий зориулалтын нисэхийн салбарыг хөгжүүлэх төрийн бодлогын үр өгөөжийг зардал-үр өгөөжийн шинжилгээний аргаар хийсэн судалгааны ажил төдийлөн их биш байна. Нэн ялангуяа ерөнхий зориулалтын нисэхийн салбар хөгжөөгүй, дэд бүтцийн хөгжил тааруу, үндэсний аялал жуулчлалын бренд үйлчилгээ нь бүрэн хөгжиж төлөвшөөгүй коммунист командын эдийн засгийн уламжлалт сэтгэлгээ нь тасраагүй зах зээлийн эдийн засгийн харилцаатай манай оронтой ижил төстэй улс орнуудад энэ талын судалгаа бага хийгдсэн байна. Тиймээс энэ орон зайг бидний судалгааны ажлын хувь нэмэр, шинэлэг тал болно гэж үзэн энэхүү судалгааны сэдвийг хөндөн судалгааны ажлаа эхлүүлсэн.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Энэхүү судалгааны ажилд ерөнхий зориулалтын нисэхийн логистикт түшиглэсэн аялал жуулчлалын хөгжил орон нутгийн эдийн засгийг тэлэхэд үзүүлэх үр нөлөөг судлах судалгааны зорилтоо биелүүлэхдээ “зардал үр өгөөжийн шинжилгээ”-ний аргыг сонгон хэрэглэсэн. “Зардал үр өгөөжийн шинжилгээ” нь хязгаарлагдмал нөөцийг хувиарлах нэн ялангуяа хаана, хэр хэмжээгээр хөрөнгө оруулалт хийх төрийн бодлогын шийдвэрийг гаргахад өргөн хэрэглэдэг хүлээн зөвшөөрөгдсөн хэмжүүрийн арга юм. Шинэ эдийн засгийн “зардал үр өгөөжийн шинжилгээ”-ний загварын хувьд санхүүгийн үр өгөөж, нийтийн үр өгөөж гэсэн хоёр төрлийн үр өгөөжийг зэрэг тооцон төрийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр өгөөжийг тооцоолон боддог (Robertson Lee, Skelly Chris, Phillips David, 2019).

Санхүүгийн үр өгөөж гэдэг нь бусад төрийн үйлчилгээний хөтөлбөрүүдэд шууд хэмнэлт гарч улмаар төрийн зардал багасах үр дүнг хэлдэг. Харин, нийтийн үр өгөөж гэдэг нь хөтөлбөрөөс гарах эдийн засаг, нийгмийн өргөн цар хүрээтэй үр нөлөөг хэлнэ. Жишээлбэл эдийн засгийн өсөлт, ажлын байр нэмэгдэх, хөрсний доройтол эсхүл цөлжилт буурах гэх томоохон хэмжээний эдийн засаг, нийгэм, байгаль орчинд гарах өөрчлөлтүүд нийгмийн үр нөлөөнд орно (Robertson Lee, Skelly Chris, Phillips David, 2019).

“Зардал үр өгөөжийн шинжилгээ”-г хийхэд хөтөлбөрүүдийн зардал болон үр өгөөжийн мөнгөний үнэ цэнийг давхар тооцоолох шаардлага гардаг. Хөтөлбөрийн зардлыг үнэн зөв тооцоолоход хэцүү байдаг боловч мөнгөний үнэ цэнийг тооцох нь илүү хэцүү байдаг.


Энэхүү судалгааны ажилд мөнгөний үнэ цэнийг тооцохдоо “хямдруулалтын хувь” -ийн аргыг ашиглан орж ирэх мөнгөн урсгал буюу ерөнхий зориулалтын нисэхийн эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг тооцож гаргасан. Мөнгөний үнэ цэнийн тооцоог хийхдээ дор харуулсан томъёог хэрэглэсэн.

$$CF/(1 + r)^n \quad (1)$$

Энд CF – орж ирэх мөнгөн орлого; r – хямдруулалтын хувь; n – тухайн жил
Тус судалгааны ажлын хүрээнд аялал жуулчлалын зорилгоор ЕЗН-ийг хөгжүүлэх эдийн засгийн үр өгөөжийг тооцохдоо үр өгөөж зардлын шинжилгээний аргыг хэрэглэсэн. Уг аргаар төрийн оролцооны хөтөлбөрийн үр өгөөжид үнэлгээ хийхдээ уг хөтөлбөрт зарцуулсан зардал болон хөтөлбөрийг хэрэгжүүлсний хүрээнд орж ирэх мөнгөн урсгал буюу орлогыг харьцуулан авч үздэг.

Хэрэв үр өгөөж-зардлын харьцаа > 1 -ээс их байвал төслийг хэрэгжүүлж болох буюу ашигтай төсөл юм гэж үзнэ. Харин үр өгөөж-зардлын харьцаа < 1 -ээс бага байвал эдийн засгийн үр өгөөж багатай ашиггүй хөрөнгө оруулалт байна гэж үздэг. Үр өгөөжийн хэмжээг нэгээс хэр их илүү байгаагаар тогтоодог.


Зураг 1. Үр өгөөж, зардлын харьцааны шинжилгээ



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Дээр харуулсан томъёог хэрэглэн орж ирэх “мөнгөн урсгал” буюу нэг жилд орох орлогыг тооцон гаргахын тулд эхлээд сүүлийн найман жилийн гадаад жуулчдын дундаж тоог тооцоолон гаргасан. Дор графикд харуулсан үр дүнг КОВИД 19-өөс өмнөх үе буюу Өмнөговь аймгийн гадаад жуулчдын 2012-2019 оны хоорондох статистик тоон мэдээллийг цуглуулж, уг найман жилийн дундажар гадаад жуулчдын дундаж тоо хэмжээг тооцож гаргасан. Сүүлийн найман жилийн дундажар нэг жилд тус аймагт 24807.75 гадаад жуулчин ирдэг байна.

Зураг 2. Гадаад жуулчдын тоо



Дараа нь Өмнөговь аймагт ирээд, аймаг дотор хэдэн өдөр аялдаг тоог тогтоосон. Тус аймгийн жуулчны баазуудаас авсан мэдээллээр тооцоход дундажар 5-6 өдөр зарцуулдаг тоо мэдээ гарсан.

Гадаад жуулчид Өмнөговь аймагт өнгөрүүлдэг дундаж өдрийг тогтоосны дараа өнөөгийн Монголын ерөнхий зориулалтын чиглэлээр бизнес эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээс дундажар 2 цаг нэг онгоцыг жуулчдад


хөлслөхөд авдаг төлбөрийн мэдээллийг цуглуулсан. Уг мэдээллийг онгоцны загвар тус бүрээр нь дор жагсаан гаргалаа. Дор харуулсан хүснэгт дээрх өгөгдлөөр бол нэг онгоцыг хоёр цаг хөлслөх дундаж төлбөр нь \$2,242.86 ам доллар болжээ.

Хүснэгт 2. ЕЗН-ийн онгоцны зардал

№	Онгоцны загвар	Цагийн хөлс
1	Цессна 208	\$2,000.00
2	Ми171	\$ 2,500.00
3	Н125	\$2,200.00
4	Р66	\$1,300.00
5	Ми8	\$2,500.00
6	Н145	\$2,400.00
7	ЕС145	\$2,800.00
Total		\$15,700.00
Average		\$2,242.86

ЕЗН-ийн онгоцны зардлыг тооцон гаргасны дараа нэг жуулчин Өмнөговь аймагт нэг удаа ирэхдээ 6 өдөр байдаг гэж үзэн нэг жуулчин нэг удаа ирэхдээ ерөнхий зориулалтын нисэх үйлчилгээ орсон 6 өдрийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сонгон үйлчлүүлсэн тохиолдолд нисэх онгоц хэрэглэсэнтэй холбоотойгоор орж ирэх мөнгөн урсгал буюу орлогыг тооцон гаргасан. Энэ 6 өдрийн ЕЗН-ийн аялал жуулчлалын зөвхөн онгоцны зардлаас орж ирэх мөнгөн урсгалыг тооцон гаргахдаа онгоцны дундаж төлбөр(\$2,242.86)-ийг 6 өдөрт үржүүлэн \$13,457.14 гэсэн орлогыг тооцон гаргалаа. Энэ мэдээлэл дээр тулгуурлан Өмнөговь аймагт жилд ирэх дундаж жуулчдын 10%, 50%-ийг ЕЗН-ийн үйлчилгээнд хамруулахад нэг жилд болон 10 жилд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоолон гаргасан.

Зураг 3. Нэг жил, Арван жилд орох мөнгөн урсгалын тооцоолол



Зураг 3 дээр харуулсан Өмнөговь аймагт жилд ирэх дундаж жуулчдын 10%, 50%-ийг ЕЗН-ийн үйлчилгээнд хамруулахад нэг жилд орж ирэх мөнгөн урсгалын мэдээллийг хэрэглэн ЕЗН-ийн оролцоотой аялал жуулчлалыг хэрэглэхэд эдийн засгийн үр өгөөжийг хэр хэмжээтэй байхыг тодорхойлсон үр өгөөж зардлын шинжилгээг хийсэн. Үр өгөөж зардлын харьцааны шинжилгээг хэрэглэн судалгааны ажлын гурван таамаглалыг шалгасан.

Эхлээд “Ерөнхий зориулалтын нисэхийн тээврийн логистик дээр түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь Өмнөговь аймгийн “Гурван сайхан” нисэх онгоцны буудлын орлогын гүйцэтгэлийг нэмэгдүүлнэ” гэсэн нэгдүгээр судалгааны таамаглалыг шалгасан. Уг таамаглалыг шалгахдаа нэг

жилд ирэх гадаад жуулчдын 10% буюу 2480.775 жуулчин ерөнхий зориулалтын нисэхийн үйлчилгээг авна гэж тооцсон.

Гурван сайхан онгоцны буудлыг 2007 онд 10 тэрбум төгрөгөөр буюу 2021 оны 11 дүгээр сарын Монгол банкны 4180.9 ам долларын ханшаар тооцвол \$2,391,829.51 ам доллараар барьж ашиглалтанд оруулсан байдаг. Тиймээс үр өгөөж зардлын шинжилгээг хийхдээ анхны хөрөнгө оруулалтын зардлыг \$2,391,829.51 ам доллар гэж тооцсон.

ЕЗН-ийн оролцоотой аялал жуулчлалыг хөгжүүлэх тус аймгийн орон нутгийн хөтөлбөр хэрэгжсэн үед нэг онгоц нэг өдөр Гурван сайхан онгоцны буудалд хоёр удаа буулт хийхэд \$200 ам доллар төлнө гэж үзвэл 6 өдөрт \$1200 ам долларын орлого орохоор байна.

Нийт зургийн өдрийн нэг онгоцны төлбөрөөс олох онгоцны буудлын орлогыг жуулчны 10% үржүүлэхээр нэг жилд орох орлого нь \$ 2,976,930.00 ам доллар болж байна. Эдгээр зардал, орох мөнгөн урсгалын тоон өгөгдөлд тулгуурлан дор хүснэгт 3-т харуулсан үр өгөөж зардлын харьцааны шинжилгээг хийн нэгдүгээр таамаглалыг шалгаж үзсэн.

Эхний шинжилгээний үр дүнгээс харвал $1 < 7.78$ гэсэн үр өгөөж-зардлын харьцаа гарсан байна. Нэгтэй харьцуулсан BCR нь 7.78 гарсан буюу нэгээс бараг 8 нэгжээр их тул хөрөнгө оруулалтын зардлаа нөхөж олоод зогсохгүй орон нутгийн эдийн засгийг 10 жилийн дараа \$ 18,610,539.38 ам доллараар буюу бараг 19 тэрбум доллараар тэлэх үр өгөөжтэй төсөл байна. Дээрээс нь нэмж хэлэхэд хорогдуулсан мөнгөний аргаар инфляцийн нөлөөг харгалзан тооцоолон бодсон эхний жилийн орлого \$2,716,177.01 ам доллар болсон буюу эхний жилийн орлогоороо анхны хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөхөөр харагдаж байна. Гэхдээ Өмнөговь аймагт ирж байгаа нийт жуулчдаас хамгийн багадаа 10% ЕЗН-ийн онгоцоор үйлчлүүлсэн тохиолдолд ийм үр өгөөжид хүрэх симуляцийн шинжилгээний үр дүн гарсан байна.

Хүснэгт 3. Нэгдүгээр таамаглалыг шалгах үр өгөөж, зардлын харьцааны шинжилгээ (BCR)

Анхны хөрөнгө оруулалт	\$ 2,391,829.51
Инфляцийн хувь	10%
Нэг жилийн орлого	\$ 2,976,930.00

Жил	Мөнгөн урсгал	$CF/(1+r)^n$
1	\$ 2,976,930.00	\$ 2,716,177.01
2	\$ 2,976,930.00	\$ 2,478,263.69

3	\$ 2,976,930.00	\$ 2,261,189.50
4	\$ 2,976,930.00	\$ 2,063,129.11
5	\$ 2,976,930.00	\$ 1,882,417.07
6	\$ 2,976,930.00	\$ 1,717,533.82
7	\$ 2,976,930.00	\$ 1,567,092.90
8	\$ 2,976,930.00	\$ 1,429,829.29
9	\$ 2,976,930.00	\$ 1,304,588.77
10	\$ 2,976,930.00	\$ 1,190,318.22
Төслийн үр өгөөжийн PV		\$ 18,610,539.38
BCR		7.780880409
BCR		7.78
1:BCR		1<7.78

Дараа нь “Өмнөговь аймгийн гадаад жуулчдын 50%-ийг ерөнхий зориулалтын нисэхийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамруулдаг төсөлд хөрөнгө оруулалт хийх нь орон нутгийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр өгөөжийг жинтэй нэмэгдүүлнэ” гэсэн таамаглалыг шалгасан.

Уг таамаглалыг шалгахдаа Н145 нисэх онгоцыг \$9,700,000.00 ам доллараар худалдан авах анхны хөрөнгө оруулалтын зардал гарсан гэж үзсэн. Зураг 3-т үзүүлсний дагуу нэг жилд орох мөнгөн урсгал буюу орлогыг \$166,920,717.86 гэж үзэн үр өгөөж зардлын харьцааны шинжилгээ хийсэн. Шинжилгээний үр дүн 1<758.33 буюу 1-ээс 758 нэгжээр их гарчээ. Нийт 10 жилийн хугацаанд \$7,355,848,217.28 ам доллараар орон нутгийн эдийн засгийг тэлэхээр харагдаж байна.

Тиймээс орон нутгийн эдийн засгийг тэлэхэд асар их үр өгөөжтэй хөтөлбөр болох нь нотлогсон симуляцийн үр дүн гарчээ.

Хүснэгт 4. Хоёрдугаар таамаглалыг шалгах үр өгөөж, зардлын харьцааны шинжилгээ(BCR)

Анхны хөрөнгө оруулалт	\$ 9,700,000.00
Инфляцийн хувь	10%
Нэг жилийн орлого	\$ 1,669,207,178.57

Жил	Мөнгөн урсгал	CF/(1+r)^n
1	\$ 1,669,207,178.57	\$ 1,522,999,250.52

2	\$	1,669,207,178.57	\$	1,389,597,856.32
3	\$	1,669,207,178.57	\$	1,267,881,255.76
4	\$	1,669,207,178.57	\$	1,156,825,963.29
5	\$	1,669,207,178.57	\$	1,055,498,141.68
6	\$	1,669,207,178.57	\$	963,045,749.71
7	\$	1,669,207,178.57	\$	878,691,377.47
8	\$	1,669,207,178.57	\$	801,725,709.37
9	\$	1,669,207,178.57	\$	731,501,559.65
10	\$	1,669,207,178.57	\$	667,428,430.34
Төслийн үр өгөөжийн PV			\$	7,355,848,217.28
BCR				758.3348678
BCR				758.33
1:BCR				1<758.33

Хамгийн сүүлд нь “Өмнөговь аймгийн гадаад жуулчдын 10%-ийг ерөнхий зориулалтын нисэхийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамруулдаг төсөлд хөрөнгө оруулалт хийх нь орон нутгийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр өгөөжийг жинтэй нэмэгдүүлнэ” гэсэн гурав дахь таамаглалыг шалгасан.

Гурав дахь таамаглалыг шалгахдаа мөн адил Н145 нисэх онгоцыг \$9,700,000.00 ам доллараар худалдан авах анхны хөрөнгө оруулалтын зардал гарсан гэж үзсэн. Зураг 3-т үзүүлсний дагуу нэг жилд орох мөнгөн урсгал буюу орлогыг \$33,387,171.43 гэж үзэн үр өгөөж зардлын харьцааны шинжилгээ хийлээ. Шинжилгээний үр дүн 1<15.17 буюу 1-ээс 15 нэгжээр их гарчээ. Нийт 10 жилийн хугацаанд \$147,130,307.48 ам доллараар орон нутгийн эдийн засгийг тэлэхээр харагдаж байна. Тиймээс орон нутгийн эдийн засгийг тэлэхэд асар их үр өгөөжтэй хөтөлбөр болох симуляцийн шинжилгээний дүгнэлт гарч байна.

Хүснэгт 5. Гуравдугаар таамаглалыг шалгах үр өгөөж, зардлын харьцааны шинжилгээ(BCR)

Анхны хөрөнгө оруулалт	\$	9,700,000.00
Инфляцийн хувь		10%
Нэг жилийн орлого	\$	33,387,171.43

Жил	Мөнгөн урсгал	CF/(1+r)^n
1	\$ 33,387,171.43	\$ 30,462,747.65
2	\$ 33,387,171.43	\$ 27,794,477.79
3	\$ 33,387,171.43	\$ 25,359,924.99
4	\$ 33,387,171.43	\$ 23,138,617.69
5	\$ 33,387,171.43	\$ 21,111,877.45
6	\$ 33,387,171.43	\$ 19,262,661.91
7	\$ 33,387,171.43	\$ 17,575,421.45
8	\$ 33,387,171.43	\$ 16,035,968.48
9	\$ 33,387,171.43	\$ 14,631,358.10
10	\$ 33,387,171.43	\$ 13,349,779.29
Төслийн үр өгөөжийн PV		\$ 147,130,307.48
BCR		15.16807294
BCR		15.17
1:BCR		1<15.17

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаанд зах зээлийн эдийн засгийн баримжтайгаар агаарын тээврийг хөгжүүлж ирсэн уламжлал багатай, түүхэн болон байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой, хүн амын суурьшил багатай хуучин коммунист эдийн засагтай байсан Монгол улсад аялал жуулчлал, орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор ЕЗН-ийг хөгжүүлэх боломжийг судалсан. Тус судалгааны ажлын дараа орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд аялал жуулчлалын зах зээл дээр суурилсан ЕЗН хоёр чиглэлээр эдийн засгийн үр өгөөж өгөх боломжтой байна гэсэн дүгнэлтэнд бид хүрсэн.

Нэгдүгээрт Өмнөговь аймгийн аялал жуулчлалын зах зээлийн жишээн дээр хийсэн ЕЗН-ийн эдийн засгийн үр өгөөжийн симуляцийн судалгаанаас харахад тус аймагт нэг жилд ирдэг гадаад жуулчдын дөнгөж 10% нь ЕЗН-ийн агаарын хөлгүүдээр үйлчлүүлэхэд орон нутгийн онгоцны буудалд орох орлого нь \$ 2,976,930.00 ам доллард хүрэх бөгөөд орон нутгийн эдийн засгийг 10

жилийн дотор ойролцоогоор 18 мянган тэрбум ам доллараар тэлэх тооцоо гарсан. Энэ бол зөвхөн Гурван сайхан онгоцны буудалд ЕЗН-ийн хөлөг онгоц бууж, хөөрөх үйлчилгээ авахад орох орлого бөгөөд агаарын хөлгийн түлш нийлүүлэх үйлчилгээ, засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл нийлүүлэх бизнес гэх мэт ЕЗН-ийн хөгжилтэй холбоотой дагаж бий болох бусад бизнесийн боломжуудыг нэмж тооцох юм бол энэ тоо хэд дахин өсөх бололцоотой юм. Энэ үр дүн нь бусад аймгуудад ЕЗН-ийн оролцоотой аялал жуулчлалыг хөгжүүлж чадвал уг аймгуудын эдийн засгийг хэд дахин нэмэгдүүлэх боломж байгааг харуулж байна.

Хоёрдугаарт судалгааны ажлын хоёр дахь симуляцийн судалгааны үр дүнгээс харвал зөвхөн Өмнөговь аймгийн гадаад жуулчдын 10%-ийн ЕЗН-ийн агаарын хөлгийг хөлслөх орлогыг 10 жилийн хугацаанд тооцож үзэхэд орон нутгийн эдийн засгийг \$147,130,307.48 ам доллараар тэлэх тооцоо гарсан. Энэ судалгааны үр дүн бол аялал жуулчлалын зах зээлд чиглэсэн ЕЗН-ийн аж үйлдвэрийг хөгжүүлж чадвал орон нутгийн эдийн засгийг тэлэх, улсын төсвийн зардлыг багасгах зорилтыг биелүүлээд зогсохгүй төрийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх боломж бүрэн байгааг харуулсан нотолгоо юм.

Цаг хугацаа, санхүүгийн хязгаарлалтаас шалтгаалан бид энэхүү судалгааг зөвхөн Өмнөговь аймгийн жишээн дээр хийсэн. Цаашид бусад аймгийн жишээн дээр ижил төстэй судалгаа хийж, үр дүнг нь хооронд нь харьцуулж судлах хэрэгцээ байна. Ирээдүйд олон судлаачид энэ чиглэлээр судалгаа явуулж, бусад орны тохиолдолуудтай харьцуулсан судалгааны ажил нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байна.

НОМ ЗҮЙ

[1] УИХ, *Алсын хараа 2050 - МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО*, Улаанбаатар, 2020.

[2] Han, J., Dai, H. & Gu, Z., "Sandstorms and desertification in Mongolia, an example of future climate events: a review," *Environ Chem Lett*, vol. 19, p. 4063–4073, 2021.

[3] UNTWO, "System of Tourism Statistics is embedded in the National Statistical System," *United Nation world tourism organisation*, 2018.

[4] Н.Сүмбэр, "Олон улсын аялал жуулчлалын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага.," www.humanities.mn, Улаанбаатар, 2019.

[5] Байгаль орчин аялал жуулчлалын яам, "2019 оны аялал жуулчлалын статистик," <https://tourism.ub.gov.mn/?p=8972>, Улаанбаатар, 2019.

[6] Fayissa, B., Nsiah, C. & Tadasse, B., "Impact of tourism on economic growth and development in Africa," *Tourism Economics*, vol. 14, no. 4, pp. 807-818, 2008.

[7] Figini, P. & Vici, L., "Tourism and growth in a cross section of countries," *Tourism Economics*, vol. 16, no. 4, pp. 789-805, 2010.

[8] Brau, R., Lanza, A. & Pigliaru, F., "How fast are tourism countries growing?," *Tourism Economics*, vol. 13, pp. 603-613, 2007.

- [9] Burgan, B. & Mules, T., "Reconciling cost-benefit and economic impact assessment for event tourism," *Tourism Economics*, vol. 4, pp. 321-330, 2001.
- [10] Dwyer L., Forsyth, P. & Spurr, R., "Assessing the economic impacts of," *Journal of Travel*, vol. 45, no. 1, p. 59-66, 2006.
- [11] Dwyer, L., Forsyth, P. & Dwyer, W., *Tourism economics and policy*, Cheltenham, UK: Channel View Publications, 2010.
- [12] A. M. Forbes, "The Trinidad Hilton: A cost-benefit study of a luxury hotel," in *Using Shadow Prices*, I. M. D. L. & M. F. G. Scott, Ed., London, Heinemann, 1976, pp. 15-42.
- [13] Raybould, M. & Mules, T., "A Cost-benefit study of protection of the Northern Beaches of Australia's Gold Coast," *Tourism Economics*, vol. 5, pp. 121-139, 1999.
- [14] N. Vanhove, "Externalities of sport and tourism investments, activities and events," in *Sport and Tourism*, 53rd AIEST Congress, St-Gall, Athens, : AIEST, 2003, pp. 237-242.
- [15] Robertson Lee, Skelly Chris, Phillips David, "Making Hard Choices in Local Public Health Spending With a Cost-Benefit Analysis Approach," *Frontiers in Public Health*, vol. 7, p. 147, 2019.
- [16] Т.Батжаргал, "Монгол Улсад Ерөнхий зориулалтын нисэх онгоцны үйлдвэрлэл, хэрэглээг өргөжүүлэх боломжийн судалгаа," Улаанбаатар, 2020.
- [17] Б.Баяр, "Аялал жуулчлалын орлого ДНБ-ий 5.4 хувийг бүрдүүлж байна," 2018. [Online]. Available: <https://ikon.mn/n/147o>.